

СЭРГЭЭН ЗАСАХ АМРАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.07.09

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Сэргээн засах амралтын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 10/21 тоот удирдамжийн хүрээнд Сэргээн засах амралтын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ж.Нямдэлгэр, Ж.Энэрэл нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Сэргээн засах амралтын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны касс, харилцах дансны үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт, захиргаа, дотоод хяналтын үйл ажиллагаа, мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, бараа материалын бүртгэл зэргийг нягталж шалгах аас гадна зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

1. Ажилчдын ажлын цагийн бүртгэлийг буруу гаргаснаар цалин хөлсний тооцоолол дээр алдаа гарсан.
2. Ажилтанд ажлын 10 хоногийн цалингүй чөлөөг олгохдоо цалингүй чөлөө олгосон талаар тушаал гаргаагүй.
3. Ээлжийн амралтаа бүрэн эдлээгүй 1-3 хоногийн өмнө ажилдаа эргэн орсон 4 ажилтанд ажилласан хугацаанд нь, ээлжийн амралттай байсан 1 ажилтанд амралттай байсан хугацаанд нь цалин бодож олгосноос ээлжийн амралтын олговор, цалин давхацсан.
4. Ажилтныг ээлжийн амралттай байх хугацаанд нь ажилласнаар тооцож цалин бодож олгосноос гадна тухайн сарын ажлын хоногоос илүү хоногоор ажлын хоногийг тооцсоноос 1 ажилтанд цалин хөлс илүү бодож олгосон.
5. Нягтлан бодох бүртгэлийн програм дээр өөрийн нэгжид ашиглах боломжтой модулуудыг бүрэн хэрэглэж чадахгүй байгаагаас бүртгэл хөтлөлт удаашралтай, хэт гар ажиллагаатай байна.
6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж шууд худалдан авалт хийж байсан дутагдлаа засаж, ДАА-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.
7. 2021 онд худалдан авалтын үйл ажиллагаандаа төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох www.tender.gov.mn-ыг ашиглаж эхэлсэн, ажилтнуудаа худалдан авах ажиллагааны сургалтад хамруулан АЗ сертификаттай болгосноор худалдан авах ажиллагааг хуулийн дагуу явуулах болсон байна.
8. ХАБЭА-н ажлыг хариуцсан ажилтнууд ИНЕГ-ын даргын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/688 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй. Гурван шатны хяналтын дэвтрийг үйл ажиллагаандаа ашигладаггүй байсныг шалгалтын хугацаандаа залруулах арга хэмжээ авч үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн.

9. Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаа хоцроох, буруу, дутуу мэдээлж байсан дутагдлаа залруулан ажиллаж байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Сэргээн засах амралтад 6 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА